**АГУУЛГА**

**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.......... 3**

1.2 Төслийн хүчин чадал .......... 4

1.3 Төслийн технологи.......... 4

1.4 Түүхий эд туслах материал.......... 4

1.5 Төслийн усан хангамж.......... 4

1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр.......... 4

**ХОЁР. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.......... 5**

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээий төлөвлөгөөний биелэлт.......... 5

2.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ.......... 7

2.1.2. Дуу чимээнээс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ.......... 10

2.1.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ.......... 10

2.1.4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ.......... 12

**ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН БИЕЛЭЛТ.......... 13**

**ДӨРӨВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.......... 16**

**ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ .......... 24**

5.1. Хатуу хог хаягдал.......... 24

5.2. Шингэн хог хаягдал .......... 24

**ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .......... 26**

6.1. Агаарын шинжилгээ.......... 26

6.2. Усны шинжилгээ.......... 27

6.3. Хөрсний шинжилгээ.......... 28

**ДҮГНЭЛТ .......... 29**

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг ........ 3
Зураг 2. Үйлдвэртйн зураг ........ 3
Зураг 3. Хатуу хог хаягдлын гэрээ, төлбөрийн баримт ........ 7
Зураг 4. Ариутгал гэрээ ........ 8
Зураг 5. Ариутгал байгууллагын зааварчилгаа өгсөн баримт ........ 9
Зураг 6. Ариутгал баримт ........ 9
Зураг 7. Гүний худгийн пасспорт ........ 10
Зураг 8. Усны гэрээ ........ 11
Зураг 9. Баллонтой ус худалдан авсан баримт ........ 11
Зураг 10. Арчилгаа, цэвэрлэгээний ажил хийгдэж буй байдал ........ 15
Зураг 11. Сонгинохайрхан дүүргийн онцгой байдлын албаны байцаагчын үйлдвэрт хийсэн хяналт шалгалт ........ 17
Зураг 12. Үйлдвэрийн гадна талбайд шинээр байрлуулсан галын сараа ........ 18
Зураг 13. Галын аюулгүй байдлын дүгннэлт ........ 18
Зураг 14. Эрүүл мэндийн үзлэгийн гэрээ ........ 19
Зураг 15. Эрүүл мэндийн үзлэгийн төлбөр төлсөн баримт ........ 20
Зураг 16. Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан дүгнэлт ........ 20
Зураг 17. Байгаль орчны сургалт ........ 21
Зураг 18. ХАБЭА сургалт ........ 22
Зураг 19. Ажилчид сургалтанд хамрагдаж буй байдал ........ 23
Зураг 20. Хогийн цэг ........ 24
Зураг 21. Шингэн хаягдлын бохирын цооног /10,20,40тн/ ........ 24
Зураг 22. Бохир соруулах гэрээ, төлбөрийн баримт ........ 25
Зураг 23. Агаарын шинжилгээний дүн ........ 26
Зураг 24. Баллонтой усны ерөнхий химийн шиинжилгээний дүн ........ 27
Зураг 25. Хөрсний шинжилгээний дүн ........ 28

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 5
Хүснэгт 2. Орчны тохижилт, ногоон байгууламжын төлөвлөгөөний биелэлт ........ 13
Хүснэгт 3. Осол, эрсдлийн менежмент төлөвлөгөөний биелэлт ........ 16
Хүснэгт 4. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт ........ 24
Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ........ 26

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| **Төслийн нэр:** | “Ноос, ноолуур самнах үйлдвэр” -ийн төсөл |
| **Төсөл хэрэгжүүлэгч:** | Хувийн хөрөнгө оруулалттай “Өрнөх голомт” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011454017, Регистрийн дугаар: 5348013 |
| **Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 20-р хороо, 22/4 тоот. Утас: 9418338 |
| **Төслийн байршил:** | Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт 1 га талбайд байрлана. |




Эх үүсвэр: Google earth

*Зураг 1. Талбайн байршлын зураг*



*Зураг 2. Үйлдвэртйн зураг*

### 1.2 Төслийн хүчин чадал

Ноос, ноолуур самнах үйлдвэр нь боловсруулалт хийгдээгүй түүхий эдийн хэмжээгээр тооцвол хоногт 500 кг, жилд 90 тн ноос, ноолуур самнах хүчин чадалтай ажилладаг. Нийт 27 ажилтантай үүнээс 23 үйлдвэрт 4 ажилтан үйлчилгээнд ажилладаг.

2024 онд 66 тн ноос, 334 кг бохир ноолуур авч, 46 тн ноос, 434 кг цэвэр ноолуур самнан гаргасан.

### 1.3 Төслийн технологи

Үйлдвэр нь Австрали улсын технологиор БНХАУ Шанхай хотод үйлдвэрлэгдсэн ISO9001 шаардлага хангасан байна.

- 2012 онд үйлдвэрлэгдсэн B210A маркын бутлах машин 1ш
- MDYS 200 маркын багдах машин 1ш
- A186F маркын самнах машин 36ш
- FN288 маркын ялгах 6 ш машинаар тоноглогдсон.

| | |
|---|---|
| **Агуулахад хадгалах** | Чанарын шаардлага хангасан түүхий эдийг зориулалтын агуулахад буулган хадгалана. |
| **Ангилан ялгах** | Агуулахад буусан түүхий эдийг технологийн шаардлагын дагуу харах, мэдрэх эрхтний тусламжтайгаар байгалийн болон хиймэл гэрэлтүүлэгтэй орчинд 4 төрлөөр ангилан ялгаж хураана. |
| **Угаалга** | Ноос ноолуурыг угаах үйлдвэрт угааж бэлтгэнэ. |
| **Бутлах** | Задлагдаагүй холиог бүрэн задлах, хялгасны ширхэгийг нэгэн чигт жигдлэх үүрэгтэй. |
| **Чийглэх** | Технологийн чийг авахуулах өрөөнд 24 цаг амраана. |
| **Неон гэрэлд ялгах** | Угаасан ноолуурыг неон гэрэлд харж мяндас болон бусад синтетик болон механик хольцуос ялгана. |
| **Самнах** | Үйлдвэрлэлийн орчны чийг, температурыг стандартын түвшинд барьж угаасан ноос, ноолуурын байгалийн хогт хольц, хялгасыг ялгаж самнана. |
| **Пресслэх** | Самнасан ноос, ноолуурыг стандарт хэмжээгээр шахаж преслэн агуулахад хурааж дотоодын болон олон улсын зах зээл гаргахад бэлэн болгоно. |

Үйлдвэрийн технологийн шийдлийн гол зорилт нь ноос, ноолууран түүхий эдийг самнан хялгасыг нь ялгах замаар түүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэн олон улсын стандартын шаардлагад тохирох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад зах зээлд нийлүүлэх асуудал юм.

### 1.4 Түүхий эд туслах материал

Тус үйлдвэр нь түүхий эд бэлтгэлийг баруун зүгийн засмал замын дагуу орших, Эмээлтийн орчимд өөрийн ноолуур хүлээн авах түрээсийн газраараа дамжуулан бэлтгүүлж, ноолуурыг өнгө, микроноор /дундаж голч/ нь ялган, ялгавартай үнээр худалдан хүлээж авдаг байна.

### 1.5 Төслийн усан хангамж

Ахуйн хэрэглээний усыг “Гранд хатантуул” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу баллонтой ус авч ажилчдын амны усанд ашиглаж байна. Үйлдвэрийн хэрэглээний усыг өөрийн талбайд гаргасан гүний худгаас хангах бөгөөд хоногт 0.7 $м^3$ ус хэрэглэж байна.

### 1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр

Үйлдвэр цахилгаан эрчим хүч нэгдсэн шугамд холбогдон хангаж байна. Цагт 6 тн технологийн уур гаргадаг бага оврын дулааны станцын зарчмаар ажиллана. Уурын зуух нь үйлдвэрийг технологийн уураар төдийгүй хэрэглээний халуун ус, дулаанаар хангана.

# ХОЁР. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээий төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| **2.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Тус компаний үйлдвэрийн ангилан ялгах, хялгас ялгах гэх мэт зарим цех тасгуудын технологийн процессоос гарах тоосжилт, чимээ шуугиан нь үйлдвэрийн ажлын байрны бохирдолтод нөлөөлөөд зогсохгүй орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно. | Хатуу болон шингэн хаягдлаар агаар бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах | Хатуу хог хаягдлын тусгайлсан цементэн хучилттай цэгт үйлдвэрийн хатуу хог хаягдлыг төвлөрүүлэн Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээ цэвэрлэгээний ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлж байна.<br>Шингэн хаягдлыг бохирын цооногт хадгалан “Сан гум” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу соруулдаг. | 100% |
| | Тоосжилт ихтэй хэсэгт /ангилан ялгах ширээний доор/ агааржуулалтын нэмэлт төхөөрөмж тавих | Үйлдвэрийн байранд агааржуулалтын системийг хангалттай хэмжээнд суурилуулан ажиллагааг тогтмол шалгаж байна. | 100% |
| | Агаар дахь хорт боисын хэмжээг ЗДХ-ээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын темпратур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах | Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээг баримтлан ажилладаг ба үйлдвэрээс агаарын чанарын 1 дээж авч шинжлүүлсэн. /Дэлгэрэнгүйг ОХШХ-т тусгав/. | 100% |
| | Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэх | “Улаанбаатар ариутгал” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу мэргэжлийн зааварчилгааг авч үйлдвэрийн 550 $м^2$ талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж байна. | 100% |
| | Чимээ ихтэй тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, шинэчлэл хийх арга хэмжээ авах | Тус онд үйддвэрийн тоног төхөөрөмжинд гэмтэл гараагүй болно. | 100% |
| **2.1.2. Дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ | Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх | Бүрэн хангаН ажилладаг. | 100% |
| **2.1.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Үйлдвэрлэлийн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.<br><br>Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх<br><br>Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа зохих | Үйлдвэрийн зориулалтаар их хэмжээний ус ашиглах тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан тогтоох, түүнд үндэслэн ус ашиглалтын гэрээг холбогдох газартай хийх | Үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний усыг өөрийн талбайд байрлах гүний худгаас хангаж байна. | 100% |
| | Үйлдвэрээс гарч буй бохир усанд шинжилгээ хийлгэж, тэмдэглэл хөтөлж байх | Хаягдал бохир усны шинжилгээг тус онд хийлгээгүй болно. Бохирын цооногт хадгалан гэрээт байгууллагад соруулан зайлуулсан. | 0% |
| | Унд-ахуйн усны чанарт хяналт тавих зорилгоор хими-нян судлалын шинжилгээ хийлгэж байх | Ундны усыг цэвэр ус үйлдвэрлэдэг “Гранд хатантуул” ХХК-иас авдаг ба тус байгууллагын шинжилгээний дүнг хавсаргав. | 100% |

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох, цэвэрлэх байгууламжийн ажиллагааны горимыг алдагдуулах; | Үйлдвэрийн дотор трапыг 7 хоногт 2-оос доошгүй удаа цэвэрлэх | Цэвэрлэгээний ажилтныг сар бүрээр хуваарилан гарган гүйцэтгүүлж байна. | 100% |
| | Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх | Хэрэглээний усыг зөөврөөр авдаг. | 100% |
| **2.1.4. Хөрс, ургамлан бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ** | | | |
| Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс орчны хөрс бохирдох нөхцөлтэй;<br><br>Технологийн горимыг зөрчих, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх;<br><br>Үйлдвэр болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох. | Үйлдвэрийн хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсний бохирдлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байх | ОХШХ тусгав. | 100% |
| | Үйлдвэрийн гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх | Тогтмол хийгдэж байна. | 100% |
| | Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх | Ахуйн хог хаягдлын төвлөрсөн цэгт цуглуулан Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээ цэвэрлэгээний ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа зайлуулж байна. | 100% |
| | Хатуу хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгох | Хатуу хучилттай болгосон. | 100% |

### *2.1.2. Дуу чимээнээс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ*

Үйлдвэрийн тоног төхөөрөмж нь БНХАУ – Шанхай хотод үйлдвэрлэгдсэн ISO 9001 шаардлага хангасан байдаг тул дуу чимээ багатай байдаг. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хүрээнд дуу чимээний хэмжилт хийлгэхэд 60 ДБа хэтрээгүй буюу MNS 4585:2016 Агаарын чанарын стандарт хэмжээнд байна.

### *2.1.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ*

Манай үйлдвэр нь ундны усны хэрэглээг "Гранд хатантуул" ХХК-иас 20 литрийн баллонтой цэвэр усыг авдаг. Ахуйн болон үйлдвэрийн хэрэглээний усыг өөрийн талбайд байрлах гүний худгаас татан ашигладаг.



Өрнөх Голомт ХХК

УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Байгаль орчны Сайдын 2004 оны 155 тоот тушаалаар батлав.

ӨРӨМДМӨЛ ХУДГИЙН ТЕХНИКИЙН ПАСПОРТ

ЭНЭХҮҮ ПАСПОРТЫГ ХУДАГ ЭЗЭМШИГЧ ӨМЧИЛНӨ

Сум, дүүрэг, хороо: УБ СХД

Эзэмшигч иргэн, байгууллагын нэр: Өрнөх Голомт ХХК

Өрөмдмөл худгийн нэр: өрөмдмөл

Улсын №: 11000 – 18000 – 18130 – 05473

Байршил буй газрын нэр, хаяг: УБ СХД Сонгинохайрхан 20 – 20-р хороо

Усны ашиглах гэрээний №

Ус ашиглах эрхийн бичгийн нэр №

Худаг гаргасан (аж ахуйн нэгж) тамга: Топ дриллинг ХХК

Захирал: [signature]

2019 он 4 сар 16 өдөр

Баталгаажуулсан:

.......... аймаг (нийслэл)-ийн Байгаль орчны албаны тамга

Орон хэлтсийн

Дарга: [signature]

2022 он 10 сар 05 өдөр

4

Худгийн байршлын солбилцол

Уртраг: 106° 46'37,65" E

Өргөрөг: 47° 53'6,88" N

Үнэмлэхүй өндөр: ..........м,

| Аймгийн код | Сумын код | Худгийн зориулалтын код |
|---|---|---|
| 11000 | 18000 | 06 |

УБ аймгийн, хотын СХД сумын дүүргийн, хорооны, багийн Сонгинохайрхан газар газарт, Үйлдвэр ахуй (ускуулалт, усан хангамж г.м) -д зориулан. Улаанбаатар аймгийн, (хотын) Топ дриллинг компаний Ж.Алтангэрэл менежер ахлагчтай анги, бригад DOWEK-6000 маркийн станокоор Цохилтот хөөгч аргаар уул худгийн цооногийг 2019 он 4 сарын 11-ээс 2019 он 4 сарын 13 өдөр хүртэл өрөмдөж гаргав.

5

| Анионууд | Уст үеийн № ба интервал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | №......... м | | №......... м | | №......... м | |
| | мг/л | мг, экв/л | мг/л | мг, экв/л | мг/л | мг, экв/л |
| Cl | 10,21 | 0,29 | | | | |
| $SO_4$ | 43,01 | 0,98 | | | | |
| $CO_3^{-}$ | <1,5 | — | | | | |
| $HCO_3$ | 97,62 | 1,60 | | | | |
| $NO_2$ | <0,05 | — | | | | |
| $NO_3$ | 1,85 | 0,03 | | | | |
| | | | | | | |
| Дүн | 156,7 | 2,90 | | | | |

| Катионууд | Уст үеийн № ба интервал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | №......... м | | №......... м | | №......... м | |
| | мг/л | мг, экв/л | мг/л | мг, экв/л | мг/л | мг, экв/л |
| (Na+K) | 15,96 | 0,66 | | | | |
| $NH_4^{+}$ | <0,10 | — | | | | |
| Ca | 37,71 | 1,88 | | | | |
| Mg... | 5,22 | 0,43 | | | | |
| Fe... | — | — | | | | |
| Fe... | — | — | | | | |
| | | | | | | |
| Дүн | 58,85 | 2,97 | | | | |

10

4. Бактериологийн шинжилгээ:

| Уст үеийн № ба интервал | Дээж авсан он, сар, өдөр | Шинжилсэн усны $1см^3$ дахь нянгийн тоо | Шинжилсэн усны хэмжээ | Коли-индекс |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

5. Усны химийн шинжилгээ хийсэн байгууллага: Ханлаб ХХК

6. Усны бактериологийн шинжилгээ хийсэн байгууллага..........

7. Усны хими, бактериологийн шинжилгээний дүгнэлт, хүн малын ундаанд хэрэглэж болох эсэх ..........

Химийн шинжилгээ хийсэн (химич) ..........

тэмдэг

Лабораторийн эрхлэгч [signature]

УЛААНБААТАР ХОТ ХАНЛАБ ХХК ТТБ4767 6603633

11

*Зураг 7. Гүний худгийн пасспорт*

### *2.1.4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ*

Тус онд хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Үйлдвэрийн талбайн хөрснөөс 1 дээж авч итгэмлэгдсэн лабораториор шинжлүүлсэн /ОХШХ тусгав/.
2. Үйлдвэрийн гадна талбайн цэвэрлэгээг гүйцэтгүүлэн ажилладаг.

## ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН БИЕЛЭЛТ

Манай байгууллага нь тус онд эзэмшил талбайд ногоон байгууламж бий болгох, тохижилтийн ажлын хүрээнд үйлдвэрийн байрны гадна цэцгийн мандал, хүлэмж байгуулан орчны тохижилтын ажил болон ажилчдын хүнсний хэрэглээний ногоог өөрсдийн хүлэмжинд тариалан ашиглаж байна.

*Хүснэгт 2. Орчны тохижилт, ногоон байгууламжын төлөвлөгөөний биелэлт*

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих | Цэцгийн мандал байгуулах | Үйлдвэрийн хашаанд цэцгийн мандал байгуулсан. | 100% |
| 2 | | Зүлэгжүүлсэн талбайд арчилгаа хийх | Тогтмол хийгдэж байна. | 100% |
| 3 | | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох | Үйлдвэрийн хашаанд 20 ширхэг улиас, гацуурны суулгацыг тариалсан. | 100% |















*Зураг 10. Арчилгаа, цэвэрлэгээний ажил хийгдэж буй байдал*

# ДӨРӨВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай байгууллагын хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг тул байгууллагын хөдөлмөр аюулгүй байдал анхаарч ажилладаг билээ. Иймд ч байгууллагын үйл ажиллагаанд Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандартуудыг баримтлан ажиллаж байна.

Үйлдвэрт осол, эрсдэлийн менежмент төлөвлөгөөг 2 чиг үүргээр баримтлан ажилладаг. Үүнд:

1. Галын аюулгүй байдал, тоног төхөөрөмж ажиллагаа, хангамж
2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
3. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг
4. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр нийт ажилчдыг сургалтанд хамруулав.

*Хүснэгт 3. Осол, эрсдлийн менежмент төлөвлөгөөний биелэлт*

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ажиллагааг өдөр тутам тогтмол шалгаж мэргэжлийн хамт олноор жилд 1 удаа тоног төхөөрөмжтөй харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж байна. | 100% |
| | Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт | | |
| | Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах | Үйлдвэрт СХД-ийн Онцгой байдлын газрын хяналтын байцаагч нарыг авч ирж галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулсан. | 100% |
| | Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу нийт үйлдвэрийн 15 ажилчдын шинжилгээнд хамруулсан. | 100% |
| | Байгаль орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт ажилчдад сургалт орох | Монголын хүрээлэн буй орчны нийгэмлэгээр нийт ажилчдыг 4 цагын сургалтанд хамруулан сертификат авсан. | 100% |



*Зураг 11. Сонгинохайрхан дүүргийн онцгой байдлын албаны байцаагчын үйлдвэрт хийсэн хяналт шалгалт*





*Зураг 12. Үйлдвэрийн гадна талбайд шинээр байрлуулсан галын сараа*



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ**

Дугаар 0018064

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: Өрнөх голомт, ХХК

Хаяг: СХД-ийн 20-р хороо, /18133/ гудамж Сонсголон 22-04 тоот

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: Үйлдвэр

Ноос ноолуур самнах үйлдвэр

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон 2024 он 02 сар 06 өдөр

Хүчинтэй хугацаа: 2026 он 02 сар 06 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

СХД-ийн аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга Хурандаа цолтой А.Алтансүх

Дүгнэлт гаргасан:

СХД-ийн аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч: Ахмад цолтой Т. Цолмонхан

/тэмдэг дарна/

*Зураг 13. Галын аюулгүй байдлын дүгнэлт*

| | |
|---|---|
| БАТЛАВ.<br>“ӨРНӨХ ГОЛОМТ”ХХК<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>Л.ГАНХУЯГ | БАТЛАВ.<br>СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН<br>ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ<br>Ц.ОДОНБАЯР |

**ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ХИЙХ ГЭРЭЭ**

Дугаар / АТ 24/31

2024 оны 05 дугаар сарын 14 өдөр Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ нь / цаашид '' Гэрээ '' гэх / нэг талаас /цаашид 'Эмнэлэг'' гэх/ түүнийг төлөөлөн Амбулаторийн эрхлэгч Г. Алтанцэцэг нөгөө талаас СХНЭ-ийг /цаашид “Өрнөх голомт ”ХХК гэх/ түүнийг төлөөлөн Л.Ганхуяг /хамтад нь талууд гэх/ Монгол улсын Иргэнии хуулиин 476-480 дугаар заалтуудыг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Үйлчлүүлэгч нь ажилтнуудад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг хийж гүйцэтгэх, эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтийг гаргах, мэргэжлийн арга зүйн заавар, зөвлөмж өгөхөд оршино.

1.2 Үйлчлүүлэгч нь бодитоор, зохих ёсоор гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан нөхцөлийн дагуу ажлын хөлсийг гүйцэтгэлээр төлөх.

1.3 Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Хийгдэх ажил, гүйцэтгэх хугацаа**

2.1 Эмнэлэг нь Үйлчлүүлэгч талын албан хаагчдын ажиллаж буй хөдөлмөрийн нөхцөлтэй уялдуулан хийгдэх шаардлагатай үзлэг шинжилгээнүүдийг тодорхойлж Үйлчлүүлэгч тай зөвшилцсөний үндсэн дээр баталж, энэхүү гэрээний Хавсралт–р тухай бүрт гаргана.

2.2 Эмнэлэг нь ажилтан, албан хаагчдыг гэрээнд заагдсан үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, үзлэгийг чанартай хийж гүйцэтгэнэ

2.3 Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалд заасны эрүүл зүйн шинжилгээнд ажилтанг гэрээнд заагдсан үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, тухайн ажил мэргэжилд эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэх талаар мэргэжлийн тохироо, дүгнэлт гаргаж өгөх ба энэ төлбөр нь гэрээний дүнд тооцогдохгүй болно.

2.4 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийг Үйлчлүүлэгч ийн товлосон хугацаанд зохих ёсоор хийж гүйцэтгэх.

2.5 Эмнэлэг нь гэрээнд заасан хугацаат үзлэгийг тогтмол хугацаанд харилцан тохиролцож хийж гүйцэтгэх ба гэрээний Хавсралт-р баталгаажуулж төлбөр тооцоог тухай бүрт гүйцэтгэлээр төлнө.

**Гурав. Төлбөр тооцоо хийх журам**

3.1 Эрүүл мэндийн үзлэгийн нэг хүний төлбөрийг энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болох хавсралт №1-т заасны дагуу тогтоосон болно.

3.2 Үйлчлүүлэгч тал урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ болох эрүүл зүйн шинжилгээний төлбөр 1 ажилтны 163,000 төгрөг нийт 2,445,000төгрөг болно.

3.3 Урьдчилан сэргийлэх дэвтрийн үзлэгийн төлбөрийг ажлын гүйцэтгэлээр барагдуулна.

3.4 Урьдчилан сэргийлэх /нийт ажилтны/ үзлэгийн төлбөрийг 40 хувийг урьдчилгаа болгон олгоно. Үлдэгдэл төлбөрийг ажлын гүйцэтгэлээр төлнө.

3.5 Урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөрийг нэхэмжлэлийн дагуу Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн Төрийн сангийн харилцах дансанд **/100200920002/** дансанд шилжүүлнэ.

**Дөрөв. Эмнэлгийн хүлээх эрх үүрэг**

4.1 Эмнэлэг нь гэрээнд заасан хугацаанд үйлчлүүлэгчийн нэрийн жагсаалтад үндэслэн үзлэг оношилгооны товлолт цагийг үйлчлүүлэгчид өгөхдөө 5-7 хоногийн өмнө мэдэгдэж баталгаажуулна.

4.2 Эмнэлэг нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тус байгууллагын эрхэлж буй ажил мэргэжлийн онцлогтой холбогдуулан мэргэжлийн байгуулагаас хийгдэх эрүүл мэндийн бүрдмэл үзлэг, шинжилгээнд үйлчлүүлэгчийн бүрэн хамруулана.

4.3 Эмнэлэг нь үйлчлүүлэгч талын хүсэлтийн дагуу шинжилгээнд орж буй үилчлүүлэгчийн харъяалал, овог, нэр, регистрийн дугаар, шинжилгээнд хамрагдсан өдөр шинжилгээ үзлэгийн талаарх мэдээллийг тухайн байгууллагын ажил хариуцсан, ажилтанд эмчид өгнө.

4.4 Урьдчилсан товлосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр холбогдох тусламж үйлчилгээг аваагүй тохиолдолд, тухайн үйлчлүүлэгчид мэдээллэж дахин товлох эсэх талаар зөвшилцөнө.

4.5 Эмнэлэг нь эрүүл мэндийн шинжилгээ хийх, үзлэг хийх газрыг үйлчлүүлэгч талд албан ёсоор бичгээр мэдээллэх ба үзлэг оношилгоонд хамрагдах үйлчлүүлэгчдийг товлосон цагийн дагуу, шуурхай, чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээг үзүүлнэ.

4.6 Эмнэлэг нь үйлчлүүлэгч талд уг гэрээний хүрээнд хамтран ажиллах, холбогдолтой бусад асуудлаар хандах, санал тавьж шийдвэрлүүлнэ.

4.5 Гэрээнд заагдсан үзлэг шинжилгээнд бүрэн хамруулахад тавигдах шаардлагыг ажилчдад урьдчилан тайлбарлаж, бэлтгэл хангуулсан байна.

4.6 Эмнэлэг нь гэрээнд заагдсаны дагуу баталгаажсан эрүүл мэндийн хуудсанд үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдаж, төвийн ерөнхий эмчээс гаргасан мэргэжлийн тохироо болон дүгнэлт гаргасан хуудсыг хүлээн авч ажилтныг ажлын байранд ажиллуулна.

4.7 Үйлчлүүлэгчийн нэр төрд халдсан үйлдлийг үл гаргах ба хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нууцыг хадгалан гэрээгээр хүлээсэн үүргээ ёс зүйтэй хэрэгжүүлнэ.

4.8 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас сөрөг үр дагавар гарсан нь /шинжилгээг буруу гаргах, нэр солигдох, шинжилгээг орхигдуулах гэх мэт/ нотлогдсон тохиолдолд тухайн үйлчлүүлэгчийн үзлэг, шинжилгээг үнэ төлбөргүй дахин хийнэ.

4.9 Үйлчлүүлэгчийн талаас эмнэлэгийн үзлэг үйлчилгээг хэвийн явуулахтай холбоотойгоор өгсөн заавар зөвлөмжийг дагаж мөрдөнө.

4.10 Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтээ эмнэлэгт тавих эрхтэй.

**Тав. Үйлчлүүлэгч талын эрх үүрэг**

5.1 Эмнэлэг нь үзлэг шинжилгээнд хамрагдахад тавигдах шаардлага, бэлтгэл ажлын талаар үзлэг эхлэхээс өмнө Үйлчлүүлэгч ид урьдчилан мэдэгдэх, зааварчилгаа өгөх үүрэгтэй.

5.2 Эмнэлэг нь ажилтнуудыг энэхүү гэрээнд заасан хугацаанд багтаан үзлэгт оруулж, үзлэгийг чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээгээр үйлчлэх үүрэгтэй.

5.3 Үзлэгийн багийн эмч нар үзлэгийг мэргэжлийн түвшинд чанартай хийж, хүн тус бүрийн эрүүл мэндийн хуудас болон амбулаторийн картан дээр үзлэгийн хариуг тодорхой бичиж, эмчилгээний заавар, зөвлөмжийг тайлбарлан бичиж өгнө.

5.4 Эрүүл мэндийн төв дээр хийгдэх ажилтнуудын эрүүл мэндийн үзлэг шинжилгээг ажлын 1–3 өдөрт багтааж хийх буюу онош тодруулах шаардлагатай ба 3 дахь шатлалын эмнэлэгт үзүүлэх, хэвтэж эмчлүүлэх шаардлагатай ажиллагсдын үзлэг тухайн цаг үеийн хугацаатай холбоотой явагдана.

5.5 Үзлэгээр өвчтэй байж болзошгүй ажилтнуудын асуудлыг эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэж асуудлыг шийдвэрлэнэ.

5.6 Хугацаат урьдчилан сэргийлэх үзлэгийн эцэст эмч тус бүр үзлэгийн дүн, зонхилон тохиолдож буй өвчлөлийг хэрхэн бууруулах талаар зөвлөмжийг гаргах ба үзлэгийг багийн ахлагч нэгтгэн, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүнг илтгэх хуудсаар дүнгийн хурал хийж Үйлчлүүлэгч талд хүлээлгэн өгнө.

5.7 Шинээр ажилд орох ажилтанг гэрээнд заасан үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндийн үзлэгийн дүн, мэргэжлийн тохироог гаргаж, тухайн ажлын байранд ажиллахад тэнцэх эсэхэд дүгнэлт гаргана.

**Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

6.1 Талууд энэ гэрээний үүргийг биелүүлэх ба харилцан бие биенээ хүндэтгэж хамтран ажиллана.

6.2 Эмнэлэг нь гэрээгээр тохирсон хугацаанд ажлыг гүйцэтгээгүй,

**Талуудын хууль ёсны хаяг:**

| Үйлчлүүлэгч : | Эмнэлэг: |
|---|---|
| СХД 20-р хороо,Сонсголон<br>18133 гудамж 22/4 тоот<br>Утас: 99967816, 775758868 | СХД-ИЙН 19-р хороо, Үйлдвэрчний гудамж, Амбулатори<br>Утас: 72728282, 88014029 |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ЭМНЭЛЭГИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| Гүйцэтгэх захирал<br>.............................<br>Л.ГАНХУЯГ | Амбулаторийн эрхлэгч<br>.............................<br>Г.АЛТАНЦЭЦЭГ |
| Нягтлан бодогч<br>.............................<br>С.РЭНЦЭНЗОО | Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал<br>.............................<br>Д.СҮНЖИДМАА |
| | Ерөнхий нягтлан<br>.............................<br>Ж.БАЯРМАГНАЙ |

*Зураг 14. Эрүүл мэндийн үзлэгийн гэрээ*

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

**НЭХЭМЖЛЭХ**

ДДТД: 000009091793000240610000001680747
Нэхэмжлэгч:
ТТД: 9091793
НЭР: Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг
Хаяг: Монгол, Улаанбаатар, Сонгинохайрхан, 19-р хороо, УЭ-ийн, Еөрийн байранд
Утас: 70174040
Э-Шуудан: jbayarmagnai@yahoo.com
Банкны нэр: Төрийн сан
Банкны дансны дугаар: 100200920002

**Хариуцагч:**
ТТД: 5348013
Нэр: Өрнөхголомт
Хаяг:
Утас: 99998868
Гэрээний №:
Огноо: 2024-06-10
Төлбөр хийх хугацаа(Хоног):

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Уьдчилан сэргийлэх үзлэг | | ш | 15 | 163,000 | 2,445,000 |

Бараа, ажил үйлчилгээний үнэ: 2,445,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар: 0
Нийслэл хотын албан татвар: 0
Нийт дүн: 2,445,000

Мөнгөн дүн: хоёр сая дөрвөн зуун дөчин таван мянган төгрөг (үсгээр)

(Тамга) Захирал:............/............/
Нягтлан бодогч:............/............/

*Зураг 15. Эрүүл мэндийн үзлэгийн төлбөр төлсөн баримт*

**“ӨРНӨХ ГОЛОМТ” ХХК –ЫН АЖИЛЧДАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРУУЛСАН АЖЛЫН ДҮГНЭЛТ**

2024.06.07 Улаанбаатар хот

СХНЭ, “ӨРНӨХ ГОЛОМТ” ХХК ын хамтын ажиллагааны гэрээг үндэслэн 2024 оны 05 дугаар сарын 22, 2024 оны 05 дүгээр сарын 24-ний өдрүүдэд нийт 15 ажилтанг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгууллаа.

Шинжилгээ авах баг бүрэлдэхүүн:

1. Амбулаторийн эрхлэгч Г.Алтанцэцэг
2. Арга зүйч М.Алтантунгалаг
3. Лабораторийн тасаг нарын бүрэлдэхүүнтэй шинжилгээний баг 2024 оны 05 сарын 21-ний өдөр давхардсан тоогоор 15 ажилтанг урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулсан. Үүнд:

- биохимийн шинжилгээний 15 сорьц
- коагулограмм 15 сорьц
- цусны ерөнхий шинжилгээний 15 сорьц
- шээсний ерөнхий шинжилгээний 15 сорьцыг авч лабораторийн тасагт хүлээлгэн өгөв.

Нийт хамрагдвал зохих 15 албан хаагчаас 15 ажилтан буюу 100 хувь нь урьдчилан сэргийлэх лабораторийн шинжилгээнд хамрагдсан байна. Мөн багажийн шинжилгээний хамрагдалт ЭКГ шинжилгээг 15, Цуллаг эрхтний хэт авиан оношлогоог 15, Цээжний рентгенд-15 ажилтан тус тус хамрагдав.

Урьдчилан сэргийлэх үзлэг хийх эмч нарын баг бүрэлдэхүүн:

1. Амбулаторийн эрхлэгч Г.Алтанцэцэг
2. Мэдрэлийн эмч С.Эрдэнэчулуун
3. Дотрын эмч Б.Наранчимэг
4. Эмэгтэйчүүдийн эмч Б.Цэрэнжав
5. Нүдний эмч Г.Эрдэнэчулуун
6. Мэс заслынг эмч Б.Тайванбат
7. ЧХХ-н эмч Б.Ичинхорлоо
8. Халдварт өвчин, Арьс харшлын эмч Г.Чанцалдулам
9. Эхоны эмч Б.Баянжаргал
10. Рентгений эмч Т.Туул
11. Рентген техникч Сувд-Эрдэнэ
12. Сувилагч Б.Ариунаа
13. Үйлчлэгч Б.Туул
14. Үйлчлэгч М.Мөнхтөвшин нарын бүрэлдэхүүнтэй үзлэгийн баг 2024 оны 05 сарын 24-ний өдөр 15 ажилтанд урьдчилан сэргийлэх эмчийн үзлэгийг хийсэн байна. Нийт хамрагдвал зохих 15 албан хаагчаас 15 албан хаагч буюу 100 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт дотор, мэдрэл , нүд, ЧХХ, эмэгтэйчүүд, эмчийн үзлэг зөвлөгөө мөн, цуллаг эрхтний хэт авиан оношлогоо, зүрхний цахилгаан бичлэг, цээжний рентген, цус, шээс биохимийн шинжилгээ авсан болно.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр /N11/-2 Сувганцрын завсрын эдийн архаг нефрит, /N39.0/-1 Шээсний замын тодорхойгүй байршилт халдвар, /J34.2/-12 Хамрын таславч муруйх, /J31.0/-4 Архаг ринит, /S02.2/-2 Хамрын ясны хугарал,/Z40.0/-1 Хорт хавдрын халгаат хүчин зүйлээс сэргийлэх мэс засал,/K86/-6 Нойр булчирхайн бусад өвчин ,/N11.8/-4 Сувганцрын завсрын эдийн бусад архаг нефрит,/N34.0/-1 Шээлүүрийн буглаа,GB polyp-1, /K86.1/-5 Бусад архаг панкреатит, Cholecystectomy-3, /K81.1/-1 Архаг холецистит, /K80/-1 Цөсний чулуу (холелитиаз), давсагны чулуу-1, /J32.9/-2 Архаг синусит, тодорхойгүй, /L40.0/-1 Жирийн псориаз Мухар олгой мэс заслаар авагдсан Appendectomy -2, /B18.1/-1 Дельта вирус хавсраагүй архаг В вирүст хепатит тус тус оношлогдсон байна.

**Цаашид авах арга хэмжээ:**

1 Эрүүл зөв хооллолтын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэх.
2 Эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэх /зөв хооллолт, биеийн жинг бууруулах/
3 Ажилчдын хоолны цэсийг эрүүл хооллолтын цэсээр баяжуулах.
4 Сэтгэл зүйн эрүүл мэнд, ажлын байрны стресс тайлах, сэтгэл зүйч эмчийн зөвлөгөө авах хэрэгцээтэй.
5 Бусад өвчин эмгэг илэрсэн ажиллагсдыг өрхийн эрүүл мэндийн төв болон дүүргийн эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд орох зөвлөгөө авах, эмчлэх.
6 Байгууллагын эмч зонхилон тохиолдох өвчнийг хяналтанд авч эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
7 Элэгний В вирусын вакцинд албан хаагчдаа бүрэн хамруулах.

ХЯНАСАН:
ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ Д.СҮНЖИДМАА

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
АМБУЛАТОРИЙН ЭРХЛЭГЧ Г.АЛТАНЦЭЦЭГ

*Зураг 16. Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан дүгнэлт*

**МОНГОЛЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НИЙГЭМЛЭГ**

# СЕРТИФИКАТ

Дугаар: 003/2024

**“ӨРНӨХ ГОЛОМТ” ХХК** нь

**“БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ”-д НИЙТ 10 АЖИЛТНАА АМЖИЛТТАЙ ХАМРУУЛСАН ТУЛ СЕРТИФИКАТ ОЛГОВ.**

**СУРГАЛТЫН АГУУЛГА:**

- Хүрээлэн буй орчны тухай ойлголт
- Ахуйн хог хаягдлын менежмент
- Аюултай хог хаягдлын менежмент
- Хөрсний бохирдол
- Усны бохирдол
- Агаарын бохирдол
- Усны хэмнэлт
- Эрчим хүчний хэмнэлт
- Хүлэмжийн хийн ерөнхий ойлголт

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ** **Б.БАТБАГАНА**

Улаанбаатар хот 2024.07.02 Хамрагдсан хугацаа: 4 цаг (АС) Хүчинтэй хугацаа: N/A

---

МОНГОЛЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НИЙГЭМЛЭГ

003/2024 дугаар сертификатын хавсралт

**Сургалтад хамрагдсан ажилтнуудын нэрсийн жагсаалт**

| Д/Д | Овог | Нэр | Албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | Балдорж | Баасанжав | Машин баригч |
| 2 | Баатар | Батбаатар | Машин баригч |
| 3 | Нүрэн | Батзориг | Машин баригч |
| 4 | Батбаяр | Цогтсайхан | Машин баригч |
| 5 | Өлзийжаргал | Гантулга | Хуулийн зөвлөх |
| 6 | Лхамжав | Ганхуяг | Захирал |
| 7 | Наранцэцэг | Ганхуяг | ХАБ Ажилтан |
| 8 | Бавуугаржид | Даваахүү | Лаборант |
| 9 | Цэндорж | Мөнхбат | Дотоод хяналтын ажилтан |
| 10 | Содовжамц | Рэнцэнзоо | Нягтлан бодогч |

Гүйцэтгэх захирал Б.Батбагана

*Зураг 17. Байгаль орчны сургалт*

МОНГОЛЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НИЙГЭМЛЭГ

# СЕРТИФИКАТ

Дугаар: НА/017/2024

**“ӨРНӨХ ГОЛОМТ” ХХК нь**

**“НИЙТ АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ”-д 10 АЖИЛТНАА АМЖИЛТТАЙ ХАМРУУЛСАН ТУЛ СЕРТИФИКАТ ОЛГОВ.**

**ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ:**

- ХАБ ба ЭА-н тухай ерөнхий ойлголт
- Ажилдаа ирж буцах үеийн аюулгүй ажиллагаа
- Ажилтны ХАБЭА-н эрх ба үүрэг хариуцлага, хандлага
- Аюул, осол, эрсдэл. Аюулын менежмент
- Энергийн хяналт ба цоож пайзын систем
- Ажлын аюулын шинжилгээ ба эрсдлийн хяналт
- АА-ны тэмдэг тэмдэглэгээ
- Гал, цахилгаан, өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа
- Дугуй ба даралтат савны аюулгүй ажиллагаа
- Өндөр эрсдэлтэй ажил ба зөвшөөрлийн систем
- Ажлын байрны орчин ба хувийн хамгаалах хэрэгсэл
- Хөдөлмөрийн нөхцөл ба хүний эрүүл мэнд
- Мэргэжлээс шалтгаалах өвчлөл ба эрүүл мэндийн үзлэг
- Ердийн өвчин, түүний урьдчилан сэргийлэлт
- Онцгой байдлын үеийн арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Б.БАТБАГАНА

Улаанбаатар хот **2024.7.18** Хамрагдсан хугацаа: **12 цаг (АС)** Хүчинтэй хугацаа: **12 сар** *(ХАБЭА-н тухай хууль 17.4)*

НА/017/2024 дугаар сертификатын хавсралт

МОНГОЛЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НИЙГЭМЛЭГ

**Сургалтад хамрагдсан ажилтнуудын нэрсийн жагсаалт**

| Д/Д | Овог | Нэр | Албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | Балдорж | Баасанжав | Машин баригч |
| 2 | Баатар | Батбаатар | Машин баригч |
| 3 | Нүрэн | Батзориг | Машин баригч |
| 4 | Батбаяр | Цогтсайхан | Машин баригч |
| 5 | Өлзийжаргал | Гантулга | Хуулийн зөвлөх |
| 6 | Лхамжав | Ганхуяг | Захирал |
| 7 | Наранцэцэг | Ганхуяг | ХАБ Ажилтан |
| 8 | Бавуугаржид | Даваахүү | Лаборант |
| 9 | Цэнддорж | Мөнхбат | Дотоод хяналтын ажилтан |
| 10 | Содовжамц | Рэнцэнзоо | Нягтлан бодогч |

Гүйцэтгэх захирал Б.Батбагана

*Зураг 18. ХАБЭА сургалт*



*Зураг 19. Ажилчид сургалтанд хамрагдаж буй байдал*

# ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт*

| Болзошгүй сөрөг нөлөөлөл | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох | Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Үйлдвэрийн талбайд ашиглагдахгүй болсон төмөр тэвшийг хогийн сав болгон ашиглаж байна. | 30% |
| Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй | Шингэн хаягдлыг зайлуулж буй цэвэршүүлэх байгууламжтай холбогдож буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, | "Сан гум" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу бохирын цооногоос соруулан зайлуулсан. | 100% |
| Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй | Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах | Ханган ажилладаг. | 100% |

## 5.1. Хатуу хог хаягдал

Үйлдвэрийн талбайд ашиглагдахгүй болсон төмөр тэвшийг хогийн сав болгон ашиглаж байна.




*Зураг 20. Хогийн цэг*

## 5.2. Шингэн хог хаягдал

Үйлдвэрийн талбайд 10, 20, 40 тн бохирын цооног байршуулсан бөгөөд тус онд "Сан гум" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу бохирыг соруулуулан зайлуулсан.





*Зураг 21. Шингэн хаягдлын бохирын цооног /10,20,40тн/*

## Хамтран ажиллах гэрээ

Улаанбаатар Хот 2024-05-08 Огноо

Нэг талаас Сан гум ххк У. Ааржаргал / цаашид “А”тал гэнэ/, түүнийг төлөөлж Нөгөө талаас Өрнөх голомт ХХК / цаашид “Б” тал гэнэ/, түүнийг төлөөлж Бид дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

### 1.Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний талууд Бохир ус соруулах, зайлуулах үйл ажиллагаа 1- удаагийн үйлчилгээ 154,000 төгрөг байхаар чиглэлээр үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр хамтран ажиллана.

1.2. Хамтран үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг талууд дараах байдлаар хариуцан гаргана. / Хөрөнгийн төрөл, бэлэн болгох хугацаа зэргийг тодорхой заана/.
- “А”тал
- “Б”тал

1.3. Хамтран үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараах байдлаар хариуцан зохион байгуулна. / хийх ажлын чиглэл, төрөл,хийгдэх хугацааг заана/:
- “А”тал
- “Б”тал

1.4. Гэрээний хугацаа 1 жил байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгэж болно.

### 2. Хамтын ажиллагааны удирдлага, хяналт

2.1. Энэхүү гэрээний 1.1.-д заасан чиглэл хэлбэрийн хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг дараах журмаар удирдан явуулна / дараах хувилбарын аль нэгийг сонгож болно/.
- “А”тал нь дангаар төлөөлөх
- “Б” тал дангаар төлөөлөх
- “А” болон “Б” талууд хамтран
- “А”болон “Б” талууд өөр этгээдийн томилох замаар

2.2. Хамтын ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлж буй тал хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг сар бүрийн хугацаанд тогтмо тайлагнах үүрэгтэй.

2.3. Гэрээний аль ч тал гэрээний хэрэгуилт, бусад талуупын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

2.4. Гэрээний аль нэг тал бусад шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлэн тавих үүрэгтэй.

### 3. Эд хөрөнгө

3.1. Хамтын үйл ажиллагаатай холбоотой саная, зардал, олсон орлого, өр, авлага, бусад зүйлс нь талуудын дараах өмчлөл байна. / дараах хувилбарын аль нэгийг сонгож өөлно/.
- хамтран өмчлөх дундын өмч
- хэсгээр өмчлөх дундын өмчид дараах хувь хэмжээгээр

3.2. Үйл ажиллагааны орлогоос бий болсон орлогын өөрт оногдох хэсгийг талууд өөрийн үзэмжээр захиран зарцуулна.

3.3. Хамтын үйл ажиллагаал үргэжлүүлэхтэй холбоотой гэрэх зардлыг талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.4. Хамтын ажиллагаанд зориулан хуримтлуулсан хөрөнгө мөнгийг зөвхөн хамтын ажиллагааны зорилгод нийцүүлэн зарцуулна.

### 4. Хариуцлага

4.1. Хамтын үйл ажиллагааны үр дүн, алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн хариуцлагыг талууд дараах зарчмаар хариуцна. / дараах хувилбарын аль нэгийг сонго /
- хувь тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
- хэсгээр өмчлөх хувь хэмжээний дагуу хариуцна.

4.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй үед нөгөө талдаа дараах торгууль эсхүл алданги төлнө / дараах хувилбарын аль нэгийг сонго/ :
- үүргийн үнийн дүнгийн _ хувийн торгууль төөнө.
- үүргийн гүцэтгэлийг хожимдуулсан хоног тутамд 0,5 хувийн / 0,5 –аас ихүй байх/ алданги төлнө.

### 5. Бусад заалт

5.1. Талууд зйл ажиллагаандаа Монгол улсын иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

5.2. Хамтын үйл ажиллагааны тайланг талууд жил тутам, явын тухай шаардлагатай тохиолдолд хэлэлцэж байна.

5.3. Талуудын хоорондын маргаан үүссэн тохиолдолд хариуцагчийн байнга газрын / шүүх, арбитр/ -аар шийдвэрлэнэ.

### 6. Гэрээ хүчин төгөлдөр байх

6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хэчин төгөлдөр болно.

6.2. Гэрээг хуульд заасанаас бусад тохиолдолд талууд / дараах хувилбарын аль нэгийг сонгож болно/
- харилцан тохиролцооны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.
- аль нэг тал нь 1 сарын өмнө урьдчилан мэдэгдэх замаар гэрээнээс татгалзаж болно. Энэ тохиолдолд тодорхой шалтгаан заагаагүй байж болно.
- онцгой нөхцөл шалтгаан бий болсон үед гэрээний аль нэг тал 1 сарын өмнө мэдэгдэж гэрээнээс татгадзаж болно. 6.3. Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

### 7. Талуудын хаяг:

| “А” тал | “Б” тал |
|---|---|
| Хаяг ,индекс: ХУД 4-р хороо 1401-12 тоот | Хаяг,индекс: СХД - 20р хороо Сонсголон-181322-4 |
| Утас: 88117809 | Утас: 99998868 |
| Факс: | Факс: |
| Цахилгаан шуудангийн хаяг: | Цахилгаан шуудангийн хаяг: |
| Банкны харилцах дансны дугаар: ХХБанк -(2615018799) Хаанбанк | Банкны харилцах дансны дугаар: |
| Гарын үсэг | Гарын үсэг |
| Тамга,тэмдэг | тамга,тэмдэг |

УЛААНБААТАР ХОТ САН ГУМ ХХК

ӨРНӨХ ГОЛОМТ ХХК

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

## ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000006414117000240807000001344815
Борлуулагчийн:
ТТД: 6414117
НЭР: Сан гум
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, 10-р хороолол, 12 тоот
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-07-31
Худалдан авагчийн:
ТТД: 5348013
Нэр: Өрнөхголомт
Хаяг:
Утас: 99998868

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир ус 7.30 | 3992000 | ш | 1 | 924,000 | 924,000 |

Бараа, ажил үйлчилгээний үнэ: 840,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар: 84,000
Нийслэл хотын албан татвар: 0
Нийт дүн: 924,000

Хүлээн авсан: .................................... /..................................../
(гарын үсэг) (нэр)

Хүлээлгэн өгсөн: .................................... /..................................../
(гарын үсэг) (нэр)

*Зураг 22. Бохир соруулах гэрээ, төлбөрийн баримт*

## ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Хянах үзүүлэлтүүд | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 1 | **Агаарын чанар:** Агаарын бохирдлын шинжилгээ, дуу чимээний хэмжилтийг хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар./ | Үйлдвэрийн хашаан дотор 2024.10.12-ны өдөр ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораториор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээний хэмжилтыг 20 минутын турш хийлгэсэн. | 100% |
| 2 | **Усны хяналт шинжилгээ** | Үйлдвэрт ус ашиглахгүй бөгөөд ажилчдын ахуйн хэрэглээний усыг зөөврөөр баллонтой ус авч ашигладаг. Иймд “Гранд хатантуул” ХХК-ийн цэвэр усны шинжилгээг хавсаргав. | 0% |
| 3 | **Хөрсний төлөв байдал, бохирдол** | Үйлдвэрийн байрны гадна талбайн өнгөн хөрснөөс 2024.10.10-ны өдөр дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид агрохими, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн. | 100% |

### 6.1. Агаарын шинжилгээ

Үйлдвэрийн хашаан дотор 2024.10.12-ны өдөр ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораториор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээний хэмжилтыг 20 минутын турш хийлгэсэн. Тус шинжилгээний дүнгээр Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй буюу бохирдолгүй гарсан.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2024/А-291
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хос Санаа" ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2024.10.12
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот СХД 20-р хороо Өрнөх Голомт ХХК Ноос,ноолуур самнах үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2024.10.14
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м³ | | | ДБА |
| 1 | Гадна талбай | X/12 | 13:10 | 0.017 | 0.033 | 0.165 | 54 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний ахлах шинжээч Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй

*Зураг 23. Агаарын шинжилгээний дүн*

### 6.3. Хөрсний шинжилгээ

Үйлдвэрийн байрны гадна талбайн өнгөн хөрснөөс 2024.10.10-ны өдөр дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид агрохими, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн.

Шинжилгээний дүнгээр үйлдвэрийн талбай нь хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламжаар бага, хөнгөн шаврансар механик бүрэлдэхүүнтэй хүнд металлийн бохирдолгүй хөрстэй байна. .



ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

Дугаар: 24/1798

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 10
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 13-14
**Дээж авсан газрын нэр:** Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо
**Координат:** -
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Өрнөх голомт” ХХК
**Харилцах утас:** 99019797

*Хөрсний химийн задлан шинжилгээний дүн*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг, % | $NO_3$ мг/100г | $CaCO_2$, % | Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5502 | Хөрс-1 | - | 9.55 | 0.64 | 1.288 | 0.29 | 0.11 | 1.98 | 10.8 | 5.4 | 1.1 | 34 |

*Хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5502 | Хөрс-1 | - | 24.7 | 34.8 | 23.6 | 7.2 | 5.4 | 4.3 | 16.9 |

*Хөрсний хүнд металл*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | *Хүнд металл мг/кг* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель/ | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 24/5502 | Хөрс-1 | - | 8.20 | ND | 30.73 | 17.86 | 60.41 | 13.81 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

*ND-not detect

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

*Зураг 25. Хөрсний шинжилгээний дүн*

Үйлдвэрийн талбайд хийгдсэн 2024 оны орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд авсан дээжнүүдээс холбогдох стандарт давсан агууламж илрээгүй буюу үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинг бохирдуулсан нөлөөлөл одоогоор байхгүй байна.

## ДҮГНЭЛТ

Манай байгууллага нь ноос, ноолуур самнах үйлдвэр төслийг Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 1.0 га талбайд үйл ажиллагааг явуулж байна. Үйлдвэр нь 2024 онд 66 тн ноос, 334 кг бохир ноолуур авч, 46 тн ноос, 434 кг цэвэр ноолуур самнан гаргасан.

Үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 2024 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний 95 орчим хувийг гүйцэтгэн ажилласан ба шингэн хаягдлыг бохир соруулах байгууллагад бохирын цооногт хадгалан соруулан зайлуулдаг тул шинжилгээ аваагүй болно.

2024 онд манай байгууллага нь байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөний хүрээнд нийт 8,300,000 орчим төгрөгийг зарцуулсан байна. Энэхүү зардал нь ус, хог, ариутгал зэрэг үйлдвэрийн зайлшгүй гарах зардлыг хасан ногоон байгууламж байгуулах, хог хаягдал, ХАБ, Байгаль орчны талаарх мэргэжлийн сургалтанд хамрагдсан зардлууд болно.